ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Батноров сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ХЭА-2022/123/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:
www.audit.mn

Чингис хот

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Б.Хуланхатан
Утас: 99008827

Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ ..... 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..... 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 9
3. Аудитын тайлан ..... 10
3.1 Ерөнхий зүйл ..... 10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..... 10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 10
3.4 Материаллаг байдал ..... 11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 12
3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 13
3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 13
3.8 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 13
3.9 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 13
4. Аудитын илрүүлэлт ..... 13
4.1. Залруулсан алдаа ..... 13
4.3. Албан шаардлага ..... 13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ..... 15
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 15
6. Аудитын тайлангийн хавсралт ..... 16
6.1. Албан шаардлага №156 /А2370452/ ХЭА-2022/123/НА-СТА-ТШЗ ..... 16

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2022.03.04 № 230

танай ______________ -ны № ________________ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ А.БОРЧУЛУУН ТАНАА

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Батноров сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Батноров сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭРДЭНЭБААТАР

E:/DOTOOD AJIL/БХ 2022/явсан бичиг/А4 20220309 230

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **99,684,698.67** | **110,656,698.67** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 2,000,000.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 2,000,000.00 |
| **3121** | **Төгрөг** | - | 2,000,000.00 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | | 2,000,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 99,684,698.67 | 108,656,698.67 |
| **354** | **Хангамжийн материал** | 72,144,698.67 | 79,936,698.67 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 716,000.00 | 1,006,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 71,428,698.67 | 78,930,698.67 |
| 35600 | Мал амьтад | 27,540,000.00 | 28,720,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,145,636,992.31** | **1,341,610,550.84** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,145,636,992.31 | 1,341,610,550.84 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,026,570,992.31 | 1,222,544,550.84 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 794,979,101.00 | 999,708,736.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (109,746,762.03) | (148,726,794.65) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 155,404,800.00 | 104,904,800.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (109,088,333.68) | (26,507,222.24) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 402,614,041.55 | 431,894,041.55 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (182,510,839.92) | (226,710,024.49) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 40,561,478.50 | 59,142,578.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (11,804,118.11) | (15,325,938.83) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 11,000,000.00 | 11,000,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 72,494,500.00 | 72,494,500.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (37,332,875.00) | (39,330,125.00) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 119,066,000.00 | 119,066,000.00 |
| 39301 | Програм хангамж | 400,000.00 | 400,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (400,000.00) | (400,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 119,066,000.00 | 119,066,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,245,321,690.98** | **1,452,267,249.51** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,245,321,690.98** | **1,452,267,249.51** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,245,321,690.98 | 1,452,267,249.51 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 507,742,322.84 | 507,742,322.84 |
| 51101 | Өмч: - төрийн | 507,742,322.84 | 507,742,322.84 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 650,004,029.98 | 856,949,588.51 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 332,704,878.84 | 650,004,029.98 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 317,299,151.14 | 206,945,558.53 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 87,575,338.16 | 87,575,338.16 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,245,321,690.98** | **1,452,267,249.51** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа:2021.12.31 /Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **827,343,089.67** | **900,513,438.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **368,917,317.67** | **260,310,735.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 368,917,317.67 | 260,310,735.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 368,917,317.67 | 260,310,735.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,600,000.00 | 3,600,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 367,317,317.67 | 256,710,735.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **458,425,772.00** | **640,202,703.00** |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 16,316,172.00 | 100,535,203.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 7,625,002.00 | 14,578,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,600,000.00 | 4,155,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,663,670.00 | 77,417,203.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон | 2,427,500.00 | 4,385,000.00 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 442,109,600.00 | 539,667,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 442,109,600.00 | 539,667,500.00 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **494,246,781.75** | **693,567,879.47** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **494,246,781.75** | **633,567,879.47** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **465,938,424.26** | **593,972,687.63** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **248,106,469.00** | **262,095,769.00** |
| 210101 | Үндсэн цалин | 162,677,335.86 | 189,208,104.76 |
| 210102 | Нэмэгдэл | 54,736,608.54 | 47,923,590.24 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,528,805.60 | 2,666,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 27,163,719.00 | 22,298,074.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **31,600,139.51** | **34,683,296.16** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,932,628.00 | 24,403,533.25 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,493,605.16 | 2,674,513.59 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,984,807.86 | 2,099,291.51 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 469,604.47 | 502,119.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | **4,719,494.02** | **5,003,838.14** |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 29,134,418.00 | 39,800,194.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,938,725.00 | 8,008,677.00 |
| 210302 | Түлш, халаалт | 20,559,693.00 | 30,591,517.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 636,000.00 | 1,200,000.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **27,953,650.00** | **25,994,133.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,326,620.00 | 3,093,870.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,869,130.00 | 19,455,063.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,084,300.00 | 2,658,100.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 323,600.00 | 187,900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 868,900.00 | 599,200.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,481,100.00 | |
| 2105 | **Нормативт зардал** | **1,738,400.00** | **1,285,000.00** |
| 210502 | Хоол, хүнс | - | 695,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,738,400.00 | 590,000.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **6,720,400.00** | **8,330,165.00** |
| 210604 | Урсгал засвар | 6,720,400.00 | 8,330,165.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | **5,091,500.00** | **4,839,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,091,500.00 | 4,839,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **12,574,496.00** | **24,157,222.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11,456,970.00 | 18,369,895.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 540,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 95,625.00 | 459,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 282,001.00 | 240,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,000.00 | 55,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 4,200,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 327,900.00 | 292,427.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **103,018,951.75** | **192,787,908.47** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,396,152.00 | 85,420,732.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,560,000.00 | 750,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 78,062,799.75 | 106,617,176.47 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **28,308,357.49** | **39,595,191.84** |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | **8,869,100.00** | **10,480,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 8,869,100.00 | 10,480,000.00 |
| 2134 | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **19,439,257.49** | **29,115,191.84** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 19,422,257.49 | 29,115,191.84 |
| 213405 | **Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг** | 17,000.00 | |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | - | 60,000,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 60,000,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 60,000,000.00 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **333,096,307.92** | **206,945,558.53** |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 15,797,156.78 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 587,156.78 | |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 15,210,000.00 | |
| 4 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **(15,797,156.78)** | **-** |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 317,299,151.14 | 206,945,558.53 |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа:2021.12.31 / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **507,742,322.84** | **87,575,338.16** | **332,704,878.84** | | **928,022,539.84** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **507,742,322.84** | **87,575,338.16** | **332,704,878.84** | - | **928,022,539.84** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 317,299,151.14 | | **317,299,151.14** |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **507,742,322.84** | **87,575,338.16** | **650,004,029.98** | - | **1,245,321,690.98** |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | | | | - | - |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | | | - | - |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 206,945,558.53 | | **206,945,558.53** |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **507,742,322.84** | **87,575,338.16** | **856,949,588.51** | - | **1,452,267,249.51** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа:2021.12.31 /Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **460,025,772.00** | **643,802,703.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,600,000.00** | **3,600,000.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 1,600,000.00 | 3,600,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,600,000.00 | 3,600,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,600,000.00 | 3,600,000.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **458,425,772.00** | **640,202,703.00** |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 16,316,172.00 | 100,535,203.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 7,625,002.00 | 14,578,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,600,000.00 | 4,155,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,663,670.00 | 77,417,203.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,427,500.00 | 4,385,000.00 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **442,109,600.00** | **539,667,500.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 442,109,600.00 | 539,667,500.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **427,178,382.00** | **520,522,703.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **427,178,382.00** | **520,522,703.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **398,942,024.51** | **480,927,511.16** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **248,106,469.00** | **262,095,769.00** |
| 210101 | Үндсэн цалин | 170,159,611.86 | 189,208,104.76 |
| 210102 | Нэмэгдэл | 47,254,332.54 | 47,923,590.24 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,528,805.60 | 2,666,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 27,163,719.00 | 22,298,074.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **31,600,139.51** | **34,683,296.16** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,932,628.00 | 24,403,533.25 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,493,605.16 | 2,674,513.59 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,984,807.86 | 2,099,291.51 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 469,604.47 | 502,119.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,719,494.02 | 5,003,838.14 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **29,134,418.00** | **39,800,194.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,938,725.00 | 8,008,677.00 |
| 210302 | Түлш, халаалт | 20,559,693.00 | 30,591,517.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 636,000.00 | 1,200,000.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **26,372,550.00** | **26,434,133.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,182,720.00 | 3,383,870.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,869,130.00 | 19,455,063.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,128,200.00 | 2,808,100.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 323,600.00 | 187,900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 868,900.00 | 599,200.00 |
| 2105 | **Норматив зардал** | **1,738,400.00** | **1,285,000.00** |
| 210502 | Хоол, хүнс | - | 695,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,738,400.00 | 590,000.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **11,046,400.00** | **17,585,665.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 185,000.00 | 520,000.00 |
| 210602 | Тавилга | - | 8,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,861,400.00 | 9,065,665.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | **5,091,500.00** | **4,839,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,091,500.00 | 4,839,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **13,301,996.00** | **23,754,722.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,184,470.00 | 17,967,395.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 540,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 95,625.00 | 459,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 282,001.00 | 240,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88,000.00 | 55,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 4,200,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 327,900.00 | 292,427.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **32,550,152.00** | **70,449,732.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 29,990,152.00 | 69,699,732.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,560,000.00 | 750,000.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **28,236,357.49** | **39,595,191.84** |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | **8,797,100.00** | **10,480,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 8,797,100.00 | 10,480,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 19,439,257.49 | 29,115,191.84 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 19,439,257.49 | 29,115,191.84 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **32,847,390.00** | **123,280,000.00** |
| 5 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **32,847,390.00** | **121,280,000.00** |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **32,847,390.00** | **121,280,000.00** |
| 2200 | **Дотоод эх үүсвэрээр** | 32,847,390.00 | 121,280,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 32,847,390.00 | 121,280,000.00 |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(32,847,390.00)** | **(121,280,000.00)** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | 2,000,000.00 |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | **2,000,000.00** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**Тайлант хугацаа:2021.12.31** **/ төгрөгөөр /**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **541,267,500.00** | **512,152,308.16** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **491,267,500.00** | **462,152,308.16** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **480,787,500.00** | **451,672,308.16** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **264,478,800.00** | **262,095,769.00** |
| 210101 | Үндсэн цалин | 187,442,100.00 | 189,208,104.76 |
| 210102 | Нэмэгдэл | 51,003,500.00 | 47,923,590.24 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,032,000.00 | 2,666,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 22,001,200.00 | 22,298,074.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **35,689,200.00** | **34,683,296.16** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,608,700.00 | 24,403,533.25 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,520,100.00 | 2,674,513.59 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,016,100.00 | 2,099,291.51 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 504,000.00 | 502,119.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,040,300.00 | 5,003,838.14 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **63,847,700.00** | **39,290,194.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,163,600.00 | 7,498,677.00 |
| 210302 | Түлш, халаалт | 54,484,100.00 | 30,591,517.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,200,000.00 | 1,200,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **21,757,400.00** | **21,446,690.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,828,000.00 | 2,968,870.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,115,200.00 | 15,115,120.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,944,000.00 | 2,575,600.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 271,000.00 | 187,900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 599,200.00 | 599,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **590,000.00** | **590,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 590,000.00 | 590,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **26,677,500.00** | **26,668,300.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 11,800,000.00 | 11,800,000.00 |
| 210602 | Тавилга | 8,000,000.00 | 8,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,877,500.00 | 6,868,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **5,465,100.00** | **4,839,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,465,100.00 | 4,839,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **12,975,300.00** | **12,887,327.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,100,000.00 | 7,100,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 540,000.00 | 540,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 503,500.00 | 459,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 252,000.00 | 240,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 86,000.00 | 55,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,200,000.00 | 4,200,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 293,800.00 | 292,427.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **49,306,500.00** | **49,171,732.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 48,500,000.00 | 48,421,732.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 806,500.00 | 750,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **10,480,000.00** | **10,480,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **10,480,000.00** | **10,480,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,480,000.00 | 10,480,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **50,000,000.00** | **50,000,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 50,000,000.00 | 50,000,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 50,000,000.00 | 50,000,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **541,267,500.00** | **512,152,308.16** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **539,667,500.00** | **510,552,308.16** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 539,667,500.00 | 510,552,308.16 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **1,600,000.00** | **1,600,000.00** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,600,000.00 | 1,600,000.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | - |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа:2021.12.31 / төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **100,535,203.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **40,535,203.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **40,535,203.00** |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **510,000.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 510,000.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **4,987,443.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 415,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,339,943.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 232,500.00 |
| 2105 | **Нормативт зардал** | 695,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 695,000.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,197,365.00** |
| 210604 | Урсгал засвар | 2,197,365.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **10,867,395.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,867,395.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **21,278,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,278,000.00 |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **60,000,000.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 60,000,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 60,000,000.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **100,535,203.00** |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **100,535,203.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 14,578,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,155,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 77,417,203.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,385,000.00 |
| IV | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хэнтий аймгийн Батноров сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Хуланхатан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Батноров сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 24-ны өдрийн 30 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хэнтий аймгийн Батноров сумын Засаг даргын тамгын газрын эрхэм зорилго нь "Төрийн үйлчилгээг иргэддээ хүнд сурталгүй ил тод шуурхай хүргэж, авилгаас ангид хуулиа дээдэлсэн шударга ёс хариуцлагын тогтолцоог төлөвшүүлэхэд оршино." гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Хэнтий аймгийн Батноров сумын Засаг даргын тамгын газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хэнтий аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Батноров сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Батноров сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 494.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Батноров сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 206.9 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | 2.0 | 2.0 |
| Авлага | - | - | - |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 99.7 | 108.7 | 9.0 |
| Үндсэн хөрөнгө | 1,145.6 | 1,341.6 | 196.0 |
| Нөөцийн бараа | - | - | - |
| **Нийт хөрөнгө** | **1,245.3** | **1,452.3** | **206.9** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо | 1,245.3 | 1,452.3 | 206.9 |
| Засгийн газрын оролцоо/Өмч - Төрийн/ | 507.7 | 507.7 | - |
| Өмнөх үеийн үр дүн | 650.0 | 650.0 | - |
| Тайлант үеийн үр дүн | - | 206.9 | 206.9 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 87.6 | 87.6 | - |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,245.3** | **1,452.3** | **206.9** |

Бараа материалын данс худалдаж авсан 98.7 сая, хандиваар авсан 3.4 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 12.0 сая төгрөгийн материалаар нэмэгдэж, 105.1 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж 108.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө данс худалдаж авсан 61.3 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 241.3 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, дуудлага худалдаагаар худалдсан тээврийн хэрэгслийн 100.5 сая төгрөгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,562.0 сая болж 586.3 сая төгрөгөөр буюу тайлант үеийн үр дүнгээр өссөн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1,328.9 сая төгрөгөөр буюу 52.0 хувиар буурсан нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 55.0 сая төгрөгөөр буюу 9.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бараа үйлчилгээний бусад зардал байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 613.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 71.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж 541.3 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэх 541.3 сая төгрөгийн төсөв баталсныг орон нутгийн төсвөөс 539.7 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 1.6 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон  нутгийн төсвөөс 539.7 сая, туслах үйл ажиллагааны орлого 1.6 сая, нийт 541.3 сая төгрөгийн орлогын бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 512.1 сая төгрөгийг зарцуулж 29.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 14.6 сая, ЗГНХ, ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 4.1 сая, дээд шатны төсвийн захирагчаас 77.4 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4.4 сая, нийт 100.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

Ахмадын сангийн харилцах дансанд 2.0 сая төгрөгийн санхүүжилт орж зарлага гараагүй байна

### 3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 5.0 сая төгрөгийн 1, цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 65.7 сая төгрөгийн 2, зарлагын 60.0 сая төгрөгийн 1 гүйлгээ нийт 185.7 сая төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Зөвлөмж өгөх.

<u>Өгсөн зөвлөмж</u> : Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэн холбогдох мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн, үнэн зөв мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 05 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### 3.8 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн байна.

### 3.9 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 190.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 185.7 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгч, 5.0 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

### 4.1. Залруулсан алдаа

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

### 4.3. Албан шаардлага

Аудитаар 5.0 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Батлагдсан төсвийн тэвчиж болох зардлаас 5.0 сая төгрөгийн сэргээн засах аппарат худалдаж авсан.

   *Шийдвэрлэсэн нь*: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | Батноров сумын ЗДТГ | 1 | 5.0 | | | | | 1 | 5.0 | | |
| Дүн | | 1 | 5.0 | | | | | 1 | 5.0 | | |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | Батноров сумын ЗДТГ | 1 | 185.7 | | | | | | | 1 | 185.7 |
| Дүн | | 1 | 185.7 | | | | | | | 1 | 185.7 |
| Нийт дүн | | 2 | 190.7 | | | | | 1 | 5.0 | 1 | 185.7 |

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 03 дугаар сарын 04 Дугаар 156/A2370452 Чингис хот
ХЗА 2022/123/НА СТА 7443

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Батноров сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвийн тэвчиж болох зардлаас 5.0 сая төгрөгийн сэргээн засах аппарат худалдаж авсан.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1 дугаар зүйлийн 1.4.-д “энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэж заасныг баримталж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Батноров сумын ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Борчулуун, нягтлан бодогч Б.Энхжаргал нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТОР Б.ХУЛАНХАТАН

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ОЮУНТУЯА

2317144297
СЮА0046 9074082

023843875

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 98601199